



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ

unicef 
for every child

6-15 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН СТРЕПТОКОКК БАКТЕРИЙН ХАЛДВАРААС ҮҮДЭЛТЭЙ ЗҮРХ, СУДАСНЫ ӨВЧЛӨЛИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024.05.01-07.01

УДИРДАГЧ:

Г.ОЧ, АУ-ны магистр, НЭМҮТ-ийн
НЭМҮЛЛ-ийн дарга

ЗӨВЛӨХ:

С.ӨНӨРСАЙХАН, ХУ-ны доктор,
дэд профессор, НЭМҮТ-ийн
захирал

Улаанбаатар хот, 2024 он

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА

НҮБ-ын хүүхдийн сан

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА

Нийслэлийн БЗД-ийн 69 дугаар сургууль

Нийслэлийн БГД-ийн Оюуны ундраа цогцолбор сургууль

Нийслэлийн СХД-ийн 97 дугаар сургууль

Нийслэлийн СБД-ийн 2 дугаар сургууль

Нийслэлийн ХУД-ийн 52 дугаар сургууль

Нийслэлийн ЧД-ийн 117 дугаар сургууль

Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын 2 дугаар сургууль

Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын 6 дугаар сургууль

УДИРДАГЧ

Г.ОЧ, АУ-ны магистр, Эмгэг судлаач эмч, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн дарга

ЗӨВЛӨХ

С.ӨНӨРСАЙХАН, ХУ-ны доктор, дэд профессор, НЭМҮТ-ийн захирал

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛСАН БАГ

Г.Оч, АУ-ны магистр, Эмгэг судлаач эмч, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн дарга

П.Гантуяа, ХШУ-ны магистр, Чанарын менежер

Д.Хишигбуян, БШУ-ны магистр, Нэгжийн ахлах

Б.Төгөлдөр, Нэгжийн ахлах

Ц.Цэвээнсүрэн, БУ-ны доктор, Молекул биологич

Б.Содномцэрэн, биохимич

Д.Ганбилэг, НЭМШУ-ы магистр, орчны химич

Б.Хоролгарав, ХСУ-ны магистр, Молекул биологич

О.Анужин, биохимич

Б.Мөнхжин, Микробиологич

Г.Номин, Микробиологич

Д.Мичидмаа, Биоанагаах судлаач

МЭДЭЭЛЛИЙГ КОМПЬЮТЕРТ ШИВЖ ОРУУЛСАН

Ц.Цэвээнсүрэн, БУ-ны доктор, Молекул биологич

Б.Содномцэрэн, биохимич

Д.Ганбилэг, НЭМШУ-ы магистр, орчны химич
Б.Хоролгарав, ХСУ-ны магистр, Молекул биологич
О.Анужин, биохимич
Г.Номин, Микробиологич
Д.Мичидмаа, Биоанагаах судлаач

ТАЙЛАН БИЧСЭН

Г.Оч, АУ-ны магистр, Эмгэг судлаач эмч, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн дарга
П.Гантуяа, ХШУ-ны магистр, Чанарын менежер
Д.Хишигбуян, БШУ-ны магистр, Нэгжийн ахлах

ТАЙЛАН ОРЧУУЛСАН

Г.Оч, АУ-ны магистр, Эмгэг судлаач эмч, НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-ийн дарга
Б.Хоролгарав, ХСУ-ны магистр, Молекул биологич
О.Анужин, биохимич
Г.Номин, Микробиологич
Д.Мичидмаа, Биоанагаах судлаач

СТАТИСТИК БОЛОВСРУУЛАЛТЫН БАГ

Д.Хишигбуян, БШУ-ны магистр, Нэгжийн ахлах
С.Цэгмэд, АУ-ны доктор, НЭМҮТ-ийн ЭНБД
П.Гантуяа, ХШУ-ны магистр, Чанарын менежер

ГАРЧИГ

Хүснэгтийн жагсаалт

Дүрслэлийн жагсаалт

БҮЛЭГ 1. Ерөнхий хэсэг

- 1.1 Үндэслэл шаардлага
- 1.2 Зорилго
- 1.3 Зорилт
- 1.4 Шинэлэг тал, эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийн ач холбогдол
- 1.5 Гарах үр дүн
- 1.6 Ёс зүйн асуудал

БҮЛЭГ 2. Материал арга зүй

- 2.1 Асуулгын арга
- 2.2 Үнэлгээний түүвэрлэлт, түүврийн загвар
- 2.3 Түүврийн хуваарилалт
- 2.4 Үнэлгээний мэдээлэл цуглуулалт
- 2.5 Үнэлгээнд хамруулах болон хасах шалгуур
- 2.6 Үнэлгээний асуулгын ангилал
- 2.7 Мэдээллийн бааз нэгтгэх
- 2.8 Үнэлгээний мэдээллийн боловсруулалт

БҮЛЭГ 3. Үнэлгээний үр дүн

- 3.1 6-15 настай хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй өвчлөлийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүн
- 3.2 Хоолойн арчдасны шинжилгээний үр дүн болон мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүн ба эрсдэлийн үнэлгээ
- 3.3 Сүүлийн 10 жилийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй өвчлөлийн байдал, газар зүйн зураглал
- 3.4 Стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлөөс сэргийлэх зөвлөмж

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Үнэлгээнд хамрагдсан нийт сурагчид нас, хүйсээр
- Хүснэгт 2. Тохиолдол болон хяналтын бүлэг, нас, хүйсээр
- Хүснэгт 3. Тохиолдол болон хяналтын бүлэг, хичээлийн ээлж, хүйсээр
- Хүснэгт 4. Сууцны төрөл, тохиолдол болон хяналтын бүлгээр
- Хүснэгт 5. Өрхийн орлого, тохиолдол болон хяналтын бүлгээр
- Хүснэгт 6. Стрептококк бактерийн халдвар удаан хугацаанд нөлөө үзүүлэх талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 7. Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 8. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 9. Стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн тулд хоолойн арчдасны шинжилгээ өгдөг талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 10. Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 11. Стрептококк бактерийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн, дуустал хийхийн ач холбогдлын талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 12. Та бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар
- Хүснэгт 13. Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар тохиолдол болон хяналтын бүлэг мэдлэг, хувиар
- Хүснэгт 14. Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар тохиолдлын болон хяналтын бүлэг мэдлэг, хувиар
- Хүснэгт 15. УБ хотын 6-17 насны хүүхдүүдээс стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээний хариу, дүүрэг, хувиар
- Хүснэгт 16. Сэлэнгэ аймгийн 6-17 насны хүүхдүүдээс стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээний хариу, сум, хувиар
- Хүснэгт 17. Гэр бүлийн хэн нэгэн гишүүний хоолой өвдөлтийн хувь, эрсдэл
- Хүснэгт 18. Ам дамжуулан хооллолтын хувь, эрсдэл
- Хүснэгт 19. Хүүхэд хоолойн махаа авахуулах мэс ажилбарын хувь, эрсдэл
- Хүснэгт 20. Хүүхдийн зүрх өвдөлтийн хувь, эрсдэл
- Хүснэгт 21. Өрхийн дундаж орлого, эрсдэл
- Хүснэгт 22. Шүд цооролтын хувь, эрсдэл

- Хүснэгт 23. Хичээллэх ээлж, эрсдэл
- Хүснэгт 24. Стрептококк бактерийн халдвар, эрсдэл
- Хүснэгт 25. Буйл үрэвсэлтийн хувь, эрсдэл
- Хүснэгт 26. Зүрхний архаг хэрх өвчний нас баралт улсын хэмжээнд, хүйс, оноор
- Хүснэгт 27. Зүрхний цочмог хэрх өвчний нас баралт улсын хэмжээнд, хүйс, оноор

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Стрептококк бактерийн халдвар удаан хугацаанд нөлөө үзүүлэх талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар
- Зураг 2. Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар
- Зураг 3. Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, анги, хувиар
- Зураг 4. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар
- Зураг 5. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, анги, хувиар
- Зураг 6. Стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн тулд хоолойн арчдасны шинжилгээ өгдөг талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар
- Зураг 7. Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэг, хувиар
- Зураг 8. Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэг, анги, хувиар
- Зураг 9. Стрептококк бактерийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн, дуустал хийхийн ач холбогдлын талаар мэдлэг, хувиар
- Зураг 10. Та бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, хувиар
- Зураг 11. Бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийн нэмэгдүүлдэг талаар мэдлэг, анги, хувиар
- Зураг 12. Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар, мэдлэг, хувиар
- Зураг 13. Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, хувиар
- Зураг 14. Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, анги, хувиар
- Зураг 15. 6-17 насны хүүхдүүдийн дундах стрептококк бактерийн халдварын тархалт, хувиар
- Зураг 16. УБ хотын 6-17 насны хүүхдүүдийн дундах стрептококк бактерийн халдварын тархалт, дүүрэг, хувиар
- Зураг 17. Сэлэнгэ аймгийн 6-17 насны хүүхдүүдийн дундах стрептококк бактерийн халдварын тархалт, сум, хувиар
- Зураг 18. Стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэл

- Зураг 19. Зүрхний цочмог хэрх өвчний нийт өвчлөл, 2015-2022 оны дундаж, 10'000 хүн амд, аймгаар
- Зураг 20. Зүрхний цочмог хэрх өвчний нийт өвчлөл (100-04)
- Зураг 21. Зүрхний цочмог хэрх өвчин, улсын хэмжээнд, 2015-2022 оны дунджаар
- Зураг 22. Зүрхний архаг хэрх өвчний нийт өвчлөл, 2015-2022 оны дундаж, 10'000 хүн амд, аймгаар
- Зураг 23. Зүрхний архаг хэрх өвчний нийт өвчлөл (105-09)
- Зураг 24. Зүрхний архаг хэрх өвчин, улсын хэмжээнд, 2015-2022 оны дунджаар
- Зураг 25. Зүрхний архаг хэрэх өвчний нас баралт, хүйс, оноор
- Зураг 26. Зүрхний цочмог хэрэх өвчний нас баралт, хүйс, оноор

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1 ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Стрептококкийн бактери нь ам, хоолой, хамар, арьс, бүдүүн гэдэс, давсаг, шээс, бэлгийн замаас олддог, ихэнх зүйл нь хоргүй байдаг ч зарим зүйлийн стрептококк нь хүнд хэлбэрийн хоолойн халдвараас эхлээд эрхтэн тогтолцооны өвчин хүртэл халдварыг үүсгэдэг. А бүлгийн стрептококк ялангуяа *Streptococcus pyogenes* нь хоолойны стрептококк, цочмог хэрэхийн халууралт, импетиго, целлюлит, үхжилт фасциит зэрэг олон төрлийн халдварыг үүсгэдэг. В бүлгийн стрептококк, *Streptococcus agalactiae* нь шинэ төрсөн хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, насанд хүрэгчид, хүүхдэд уушгины хатгалгаа, сепсис, менингит зэрэг ноцтой халдваруудыг үүсгэдэг.

Zühlke, L. J., нарын 2017 онд хийсэн “А бүлгийн стрептококк, цочмог хэрэхийн халууралт, зүрхний хэрэх өвчин: тархвар судлал ба эмнэл зүйн асуудал” судалгаагаар цочмог хэрэхийн халууралтыг өдөөж буй этиологийн үүсгэгч нь А бүлгийн β -цус задлагч стрептококк болохыг тодорхойлсон. Мөн энэ халдвар нь нас ахих тусам буурдаг, бүс нутгаас хамаарч тархалтыг өөр байгааг тогтоожээ¹.

А бүлгийн стрептококкийн халдвар нь цочмог хэрэхийн халууралт, зүрхний хэрэх өвчинд хүргэдэг гол хүчин зүйл болохыг тодорхойлсон байна. Зүрхний хэрэх өвчин голчлон хүүхэд, залуучуудад нөлөөлдөг бөгөөд архаг зүрхний хэрэх өвчин нь хэм алдагдал, системийн эмболи, халдварт эндокардит, уушгины гипертензи, зүрхний дутагдал, үхэл зэрэг хүндрэлүүдээр илэрдэг хавлагийн регургитаци эсвэл нарийслаар тодорхойлогддог гэж үзжээ².

А бүлгийн стрептококк нь цочмог үрэвсэлт өвчнүүдийг үүсгэдэг бөгөөд эмчлэхгүй, дутуу эмчилсэн тохиолдолд зүрхний хэрэх өвчинд хүргэдэг. Зүрхний хэрэх өвчин өмнө нь халдварласан стрептококкийн халдвараас үүдэлтэй, аутоиммуны хариу урвалын улмаас зүрхний хавлагийг гэмтээдэг бөгөөд жил бүр энэ өвчнөөр дэлхийн хэмжээнд 288,348 хүн нас бардаг³. Эпидемиологийн судалгаагаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал нийгэм, эдийн засаг хөгжиж буй орны хүн амын дунд стрептококкийн халдвар мөн стрептококкийн халдварын хүндрэл болох зүрхний хэрэх өвчин их байна⁴.

Мөн Zühlke, L. J., нарын 2021 онд хийсэн “А бүлгийн стрептококкийн халдвар, цочмог хэрэхийн халууралт, зүрхний хэрэх өвчнийг бууруулах анхан шатны арга хэмжээний бүтэцтэй тойм” судалгаагаар Номхон далайн бүс нутгийн хүүхдүүдийн дунд зүрхний хэрэх өвчин, А бүлгийн стрептококкийн фарингит их байгааг тогтоосон. Тиймээс эрт

оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг судлах нь зүйтэй гэж судлаачид үзжээ⁵.

А бүлгийн стрептококкийн үрэвсэлт өвчнөөр өвчилсөн хүмүүст зүрхний шигдээс, зүрхний дутагдал, цус харвалт зэрэг зүрх судасны бусад хүндрэлүүд үүсэх эрсдэл нэмэгдэж байгааг олон улсын судалгаанууд харуулж байна⁶.

Хэрэхийн халууралт, А бүлгийн стрептококкийн фарингит эсвэл стрептококкийн хоолойн халдварын аутоиммуны үрэвслийн урвалаас урагт зүрхний төрөлхийн гажиг үүсгэдэг. Тиймээс стрептококкийн бактерийн халдвар, зүрхний хэрэх өвчин, зүрх судасны эрсдэлийн харилцан үйлчлэлийн талаар судалж, хүн амын дунд зүрх судасны өвчлөлийг бууруулах, зорилтот арга хэмжээ, бодлогын шийдвэрт нөлөөлөхүйц үр дүн, нотолгоонд суурилсан мэдээлэл өгөх шаардлагатай байна.

1.2 ЗОРИЛГО

Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн 6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийг үнэлэх;

1.3 ЗОРИЛТ

Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн 6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийг үнэлэхийн тулд дараах зорилтуудыг тавилаа. Үүнд:

1. Стрептококк бактерийн халдварын талаарх 6-15 настай хүүхдүүдийн мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох;
2. Стрептококк бактерийн шинжилгээний хариуг мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүнтэй харьцуулж, эрсдэлийг үнэлэх
3. Сүүлийн 10 жилийн өвчлөлийн байдлыг тодорхойлох;
4. Зөвлөмж боловсруулах

1.4 ШИНЭЛЭГ ТАЛ, ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Зүрхний олдмол гажиг, хоолойн үрэвсэлт өвчнийг үүсгэдэг стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдсан 6-15 насны хүүхдүүдийн дунд стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийг үнэлэх үнэлгээний асуумжаар мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлно. Мөн стрептококк бактерийн шинжилгээний хариуг мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүнтэй харьцуулж, эрсдэлийг үнэлж, зөвлөмж боловсруулснаар хүн амын дунд зүрх судасны өвчлөлийг бууруулах, зорилтот арга хэмжээ, бодлогын шийдвэрт нөлөөлөхүйц үр дүн, нотолгоонд

суурилсан мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх, эмчилгээг бүрэн хийхийн ач тусыг ойлгуулснаар ирээдүйд стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийг бууруулах боломжтой болно.

1.5 ГАРАХ ҮР ДҮН

1. 6-15 настай хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй өвчлөлийн талаарх мэдлэг, хандлага, дадал тодорхойлогдоно.
2. Хоолойн арчдасны шинжилгээний үр дүн болон мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүнтэй харьцуулж, эрсдэл үнэлэгдэнэ.
3. Сүүлийн 10 жилийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй өвчлөлийн байдлыг тодорхойлж, газар зүйн зураглал гарсан байна.
4. Стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлөөс сэргийлэх зөвлөмж боловсруулсан байна.

1.6 ЁС ЗҮЙН АСУУДАЛ

Үнэлгээний аргачлалыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрдмийн зөвлөлийн хурлаар 2024 оны 05 дугаар сарын 07–ны өдөр хэлэлцүүлж, батлуулсан. 6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийн үнэлгээний аргачлалыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Анагаах ухааны Ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж үнэлгээг хийх зөвшөөрөл авсан. Үнэлгээнд хамрагдсан бүх хүүхдүүд сайн дураараа оролцсон бөгөөд хүүхдүүдийн асран хамгаалагч нараас амаар болон бичгээр зөвшөөрөл авсан. Үнэлгээний мэдээлэл цуглуулах, мэдээллийн санд шивж оруулах, статистик боловсруулалт хийх, үр дүнг танилцуулах явцад оролцогчдын мэдээллийн нууцыг чанд хадгалсан болно.

БҮЛЭГ 2. МАТЕРИАЛ АРГА ЗҮЙ

Тус үнэлгээнд стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ өгсөн 6-15 насны хүүхдүүдээс стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тогтоох түргэвчилсэн үнэлгээг зорилтод бүлэгт суурилсан агшны загвараар гүйцэтгэж, мэдээллийг цуглуулсан.

2.1 Асуулгын арга

Хүн ам зүйн мэдээлэл, стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх асуулга ашиглав.

2.2 Үнэлгээний түүвэрлэлт, түүврийн загвар

Үнэлгээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг (СХД)-ийн 97, Сүхбаатар дүүрэг (СБД)-ийн 2, Чингэлтэй дүүрэг (ЧД)-ийн 117, Хан уул дүүрэг (ХУД)-ийн 52, Баянзүрх дүүрэг (БЗД)-ийн 69, Баянгол дүүрэг (БГД)-ийн Оюуны ундраа цогцолбор, Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын 2, 6 дугаар ЕБС-иудын 1-10 дугаар ангийн сурагчид болон асран хамгаалагч нар хамрагдав.

Нийслэлийн зургаан дүүргийн 6, Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын 2 сургуулийн 1-10 дугаар ангийн 703 сурагчийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Түүврийн дизайныг боловсруулахдаа зорилтот бүлгийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц нарийвчлалтай байхаар тооцоолол хийж, тохирох бүлэглэсэн түүврийн аргыг ашиглав. Нийт эх олонлогоос түүвэрлэн авсан хэсгээр төлөөлүүлэн сурагчдын мэдлэг, хандлага дадлыг тодорхойлж, үнэлгээ хийв.

2.3 Түүврийн хуваарилалт

Нэг түүврийн нэгжээс сурагчдыг сонгохдоо тухайн насны сурагчдын эх олонлогт эзлэх хувьд пропорционалиар тооцов (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Үнэлгээнд хамрагдсан нийт сурагчид нас, хүйсээр

Нас	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	п	%	п	%	п	%
6	28	4.0	36	5.1	64	9.1
7	29	4.1	26	3.7	55	7.8
8	33	4.7	33	4.7	66	9.4
9	28	4.0	38	5.4	66	9.4
10	32	4.6	41	5.8	73	10.4
11	37	5.3	47	6.7	84	11.9
12	34	4.8	42	6.0	76	10.8
13	36	5.1	30	4.3	66	9.4
14	40	5.7	38	5.4	78	11.1
15	33	4.7	42	6.0	75	10.7
Нийт	330	46.9	373	53.1	703	100

2.4 Үнэлгээний мэдээлэл цуглуулалт

Нийслэлийн СХД, СБД, ЧД, ХУД, БЗД, БГД-т 4 баг, Сэлэнгэ аймаг Сүхбаатар суманд 2 баг нийт 6 үнэлгээний мэдээллийг цуглуулахаар ажилласан. Баг тус бүр үндсэн 3 гишүүн, сургуулийн эмч, нийгмийн ажилтан гэсэн 2 сургуулийн чиглүүлэн туслагч буюу нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй байв. Сургуулийн чиглүүлэн туслагч болон багийн гишүүд хамтран санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон сурагчид болон асран хамгаалагч нарыг үнэлгээ эхлэхээс нэг өдрийн өмнө үнэлгээнд оролцохоор сонгогдсоныг мэдэгдэж, үнэлгээний зорилго, зорилтыг танилцуулсан зөвшөөрлийн хуудас хүргэж, бичгээр зөвшөөрөл өгсөн оролцогчдыг үнэлгээнд хамруулсан.

2.5 Үнэлгээнд хамруулах болон хасах шалгуур

Үнэлгээнд стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ өгсөн сонгогдсон сурагчдаас зөвхөн бичгээр зөвшөөрөл өгсөн сурагчдыг оролцуулж, стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ өгөөгүй, үнэлгээ явагдах үед өвчтэй, чөлөөтэй, тасалсан сурагчдыг үнэлгээнд хамруулаагүй болно.

2.6 Үнэлгээний асуулгын ангилал

Үнэлгээний асуумж нь 4 бүлэг бүхий нийт 80 асуултаас бүрдсэн болно. Үүнд:

1. Ерөнхий асуулт
2. Хүүхдийн талаарх ерөнхий асуумж
3. Эрсдэлт хүчин зүйлсийн талаар асуумж
4. Мэдлэг, хандлага, дадлын асуумж

2.7 Мэдээллийн бааз нэгтгэх

Хоолойн арчдасны шинжилгээний үр дүн болон үнэлгээгээр цуглуулсан мэдээллийг Microsoft Excel программд шивж мэдээллийн бааз үүсгэсэн. Нэгтгэсэн мэдээллийг нягталж, шалгаж баталгаажуулан SPSS 25 программд хөрвүүлэв.

2.8 Үнэлгээний мэдээллийн боловсруулалт

Мэдээллийн баазыг түшиглэн шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлалын дагуу статистик боловсруулалт, дүн шинжилгээ хийг SPSS 25 программ хангамж ашиглан дундаж утга, давтамжийн үзүүлэлт, магадлалын харьцаа (OR) тооцон үр дүнг (стандарт алдаа, итгэх интервал), бүлгүүдийн ялгааг тодорхойлоход 95 хувийн итгэх хязгаар (95% ИХ)-ын утгуудыг ашиглан гүйцэтгэв.

$$Odds Ratio = \frac{p(\frac{d}{s})/p(\frac{d}{s})}{p(\frac{d}{s})/p(\frac{d}{s})} = ad/bc$$

Улсын хэмжээнд стрептококк бактерийн халдвар, зүрхний хэрх өвчний тархалтыг тогтоохын тулд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс жил бүр нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн өвчлөлийг олон улсын өвчлөлийн код болон өвчний нэршлээр нь нэгтгэн гаргадаг “Эрүүл мэндийн статистик мэдээлэл II боть”-оос 2014-2023 оны хооронд нийт 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй өвчлөлийн бодит тоог түүвэрлэн цуглуулж дүн шинжилгээ хийнэ.

Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн стрептококк бактерийн халдвар, зүрхний хэрх өвчний тархалтыг тухайн орон нутгийн тухайн жилийн 10 000 хүн амд дүүрэг, аймаг тус бүрээр тооцно.

$$n = \frac{\text{Тухайн газар бүртгэгдсэн өвчлөл} \times 10000}{\text{Тухайн газрын хүн амын тоо}}$$

Улсын хэмжээнд аймаг, стрептококк бактерийн халдвар, зүрхний хэрх өвчний хөдлөл зүйг 10000 хүн амд бодсон тоог 5, 10 жилийн давтамжтайгаар харьцуулж дүн шинжилгээ хийхэд арифметик дунджийг ашиглана.

$$\text{Арифметик дундаж} = \frac{\sum x}{n}$$

Энэхүү ажлын хүрээнд хот суурин ба хөдөө орон нутгаас сонгогдох хүн амын бодит харьцааг хангах, амьдралын хэв маяг, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын ялгааг тодорхойлох зорилгоор судалгааны түүвэрлэлтийг хот хөдөөгөөр ангилан авч үзнэ.

Стрептококк бактерийн халдвар, зүрхний хэрх өвчний тархалтыг Arc view, GIS программ хангамж ашиглан, газар зүйн зураглалд оруулж гаргасан.

БҮЛЭГ 3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

3.1 6-15 настай хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй өвчлөлийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүн:

Үнэлгээнд стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ өгсөн нийслэлийн зургаан дүүргийн 6, Сэлэнгэ аймаг Сүхбаатар сумын 2 сургуулийн 1-10 дугаар ангийн 6-15 настай хүүхдүүдийг тохиолдол болон хяналтын бүлэгт хуваан санамсаргүй түүврийн аргаар сонгож үнэлгээнд хамруулсан. Тохиолдлын бүлэгт шинжилгээний хариу эерэг гарсан буюу стрептококк бактерийн халдвартай илэрсэн хүүхдүүд, хяналтын бүлэгт шинжилгээний хариу сөрөг гарсан буюу стрептококк бактерийн халдвар илрээгүй хүүхдийг тус тус сонгосон.

Нийслэлийн БЗД-ийн 69, БГД-ийн Оюуны ундраа цогцолбор, СХД-ийн 97, ЧД-ийн 117, СБД-ийн 2, ХУД-ийн 52, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 2, 6 дугаар сургуулиудын 1-10 дугаар ангийн сурагчдын сууцны төрөл, нас хүйс, орлогын үзүүлэлтүүдийг нэгтгэв.

1-10 ангийн 6-15 насны нийт 703 сурагч хамрагдсан бөгөөд хамрагсдын 330 (46.9%) сурагч нь эрэгтэй, 373 (53.1%) сурагч нь эмэгтэй хүүхдүүд эзэлж байв.

Үнэлгээнд хамрагдагсдыг тохиолдол болон хяналтын бүлгээр авч үзвэл тохиолдлын бүлэгт нийт 206 (29.3%) сурагч үүнээс 89 (43.2%) нь эрэгтэй, 117 (56.8%) нь эмэгтэй сурагчид байсан бол хяналтын бүлэгт ний 497 (70.7%) сурагч үүнээс 241 (48.5%) нь эрэгтэй, 256 (51.5%) нь эмэгтэй сурагчид байсан байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Тохиолдол болон хяналтын бүлэг, нас, хүйсээр

Нас	Тохиолдлын бүлэг						Хяналтын бүлэг					
	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	п	%	п	%	п	%	п	%	п	%	п	%
6	8	3.9	9	4.4	17	8.3	20	4.0	27	5.4	47	9.5
7	7	3.4	9	4.4	16	7.8	22	4.4	17	3.4	39	7.8
8	8	3.9	10	4.9	18	8.7	25	5.0	23	4.6	48	9.7
9	11	5.3	11	5.3	22	10.7	17	3.4	27	5.4	44	8.9
10	8	3.9	14	6.8	22	10.7	24	4.8	27	5.4	51	10.3
11	9	4.4	14	6.8	23	11.2	28	5.6	33	6.6	61	12.3
12	9	4.4	15	7.3	24	11.7	25	5.0	27	5.4	52	10.5
13	12	5.8	11	5.3	23	11.2	24	4.8	19	3.8	43	8.7
14	10	4.9	10	4.9	20	9.7	30	6.0	28	5.6	58	11.7
15	7	3.4	14	6.8	21	10.2	26	5.2	28	5.6	54	10.9
Нийт	89	43.2	117	56.8	206	100	241	48.5	256	51.5	497	100

Үнэлгээнд хамрагдагсдыг хичээллэх ээлжээр нь авч үзвэл өглөөний ээлжид хичээллэж байгаа нийт 431 (61.3%) сурагч үүнээс тохиолдлын бүлэгт **133 (18.9%)**, хяналтын бүлэгт **298 (42.4%)** сурагч байсан бол өдрийн ээлжид хичээллэж байгаа

нийт 272 (38.7%) сурагч үүнээс тохиолдлын бүлэгт **73 (10.4%)**, хяналтын бүлэгт **199 (28.3%)** сурагчид байсан байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Тохиолдол болон хяналтын бүлэг, хичээлийн ээлж, хүйсээр

Ээлж	Тохиолдлын бүлэг						Хяналтын бүлэг					
	Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	
	n	%	n	%	n	%	n	%	n	%	n	%
Өглөө	59	8.4	74	10.5	133	18.9	143	20.3	155	22.0	298	42.4
Өдөр	30	4.3	43	6.1	73	10.4	98	13.9	101	14.4	199	28.3
Нийт	89	12.7	117	16.6	206	29.3	241	34.2	256	36.4	497	70.7

Үнэлгээнд хамрагдагсдын 10.7% нь гэрт, 37.8% нь хашаа байшинд, 45.7% нь орон сууцанд, 28.0% нь нийтийн байранд тус тус амьдарч байна. Үнэлгээний дүнгээс харахад нийтийн байранд амьдрах нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг 76%-иар нэмэгдүүлж байна (OR 1.76, p=0.292)(Хүснэгт 4).

Хүснэгт 4. Сууцны төрөл, тохиолдол болон хяналтын бүлгээр

Сууцны төрөл	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Гэр	23	3.3	2.1-4.8	52	7.4	5.7-9.5	0.92	0.54-1.58	0.891
Хашаа байшин	67	9.6	7.5-11.9	198	28.2	25.0-31.7	0.70	0.49-1.01	0.058
Нийтийн байр	6	0.9	0.4-1.8	22	3.1	2.0-4.6	1.76	0.69-4.47	0.292
Орон сууц	108	15.4	12.9-18.2	225	32.1	28.7-35.6			

Үнэлгээнд хамрагдагсдын өрхийн орлогыг асуумжийн аргаар үнэлэхэд нэг саяас доош орлоготой өрх 13.0%, 1-2 сая төгрөгийн орлоготой өрх 38.0%, 2-3 сая төгрөгийн орлоготой өрх 31.2%, 3 дээш сая төгрөгийн орлоготой өрх 17.8% байлаа. Тохиолдол, хяналтын бүлгээр авч үзэхэд орлого буурах тусам стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна (OR 1.96, p=0.076) (Хүснэгт 5).


Хүснэгт 5. Өрхийн орлого, тохиолдол болон хяналтын бүлгээр

Орлогын хэмжээ	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
< 1 сая	24	16.3	11.0-22.9	49	11.8	9.0-15.2	1.96	0.98-3.91	0.076
1-2 сая	59	40.1	32.5-48.2	154	37.2	32.6-41.9	1.53	0.86-2.72	0.164
2-3 сая	44	29.9	23.0-37.7	131	31.6	27.3-36.2	1.34	0.74-2.44	0.375
> 3 сая	20	13.6	8.8-19.8	80	19.3	15.7-23.3			

Стрептококк бактерийн халдвар удаан хугацаанд эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг үнэлэхэд нийт үнэлгээнд хамрагдагсдын талаас илүү буюу 50.8% (95% CI 47.1-54.5) нь огт мэдлэггүй бол **85.8% (95% CI 83.0-88.2)** нь дунд (огт мэдлэггүй, муу, дунд)-аас доош мэдлэгтэй

байсан байна. Харин 14.3% (95% CI 11.8-17.0) нь сайн, маш сайн мэдлэгтэй гэж үнэлэгдсэн байна (Зураг 1).

Зураг 1. Стрептококк бактерийн халдвар удаан хугацаанд нөлөө үзүүлэх талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар




Стрептококк бактерийн халдвар удаан хугацаанд эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлгээр нь авч үзвэл хоёр бүлэг хоёулаа мэдлэгийн түвшин ижил муу байгаа нь мэдлэг мэдээлэл нь хангалтгүй байна (OR 0.92-1.22, $p=0.797-1.0$) (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Стрептококк бактерийн халдвар удаан хугацаанд нөлөө үзүүлэх талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	104	50.7	43.9-57.5	252	50.8	46.4-55.2	1.03	0.39-2.73	1.0
Бага мэднэ	25	12.2	8.3-17.2	68	10.9	10.9-16.9	0.92	0.32-2.63	1.0
Дунд мэднэ	44	21.5	16.3-27.5	108	18.3	18.3-25.6	1.02	0.37-2.79	1.0
Сайн мэднэ	26	12.7	8.7-17.8	53	8.2	8.2-13.6	1.22	0.43-3.53	0.797
Маш сайн мэднэ	6	2.9	1.2-5.9	15	1.8	1.8-4.8			


Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг үнэлэхэд 57.7% (95% CI 54.0-61.3) нь огт мэдлэггүй, 16.1% (95% CI 13.5-19.0) нь бага, 19.1% (95% CI 16.3-22.1) нь дунд, 6.4% (95% CI 4.8-8.4) нь сайн, 0.7% (95% CI 0.3-1.6) нь маш сайн мэдлэгтэй байсан байна (Зураг 2).

Зураг 2. Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар



Үнэлгээнд хамрагдсан сурагчдыг ангиар авч үзвэл 1-5 дугаар ангийн сурагчдын асран хамгаалагчид, 9 дүгээр ангийн сурагчдаас бусад (6, 7, 8, 10) ангийн сурагчдын 50%-иас илүү нь стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар огт мэдлэггүй байгаа нь доорх зургаас харагдаж байна (Зураг 3). Харин 3 дугаар ангийн асран хамгаалагчид (11.4%) болон 5 дугаар ангийн сурагчид (11.6%) бусад ангийн асран хамгаалагч, сурагчдаас мэдлэгийн түвшин арай илүү байлаа.

Зураг 3. Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, анги, хувиар



Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлгээр нь авч үзвэл тохиолдлын бүлэг хяналтын бүлгээс илүү их мэдээлэлтэй байна (Хүснэгт 7). Ярилцлагын явцад хоолойн арчдасны шинжилгээгээр эерэг гарсан хүүхдүүд болон асран хамгаалагч нарт сургуулийн эмч болон харьяаллын ӨЭМТ нь мэдээллээр хангасан байна.


Хүснэгт 7. Стрептококк бактерийн халдварыг эмчлэхгүй, дутуу эмчилснээс болоод зүрхний олдмол гажиг болох зүрхний хэрэх өвчинд хүргэдэг талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			

Огт мэдэхгүй	121	59.0	52.2-65.6	284	57.1	52.8-61.4	1.704	0.19-15.40	1.0
Бага мэднэ	35	17.1	12.4-22.7	78	12.7	12.7-19.1	1.795	0.19-16.65	1.0
Дунд мэднэ	31	15.1	10.7-20.5	103	17.3	17.3-24.5	1.204	0.13-11.17	1.0
Сайн мэднэ	17	8.3	5.1-12.7	28	3.9	3.9-7.9	2.429	0.25-23.57	0.642
Маш сайн мэднэ	1	0.5	0.1-2.3	4	0.3	0.3-1.9			


Нийт үнэлгээнд хамрагдсан 1-5 дугаар ангийн сурагчдын асран хамгаалагчид, 6-10 дугаар ангийн сурагчдын дунд зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх 38.8% (95% CI 35.3-42.5) нь огт мэдлэггүй, 24.0% (95% CI 21.0-27.3) нь муу, 23.9% (95% CI 20.9-27.2) нь дунд, 12.2% (95% CI 10.0-14.8) нь сайн, 1.0% (95% CI 0.4-1.9) нь маш сайн мэдлэгтэй гэж үнэлэгдсэн байна (Зураг 4).

Зураг 4. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар



Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг ангиар авч үзэхэд 5 дугаар ангийн сурагчдын асран хамгаалагчид (53.6%), 6 дугаар ангийн сурагчид (54.2%)-ын 50%-иас илүү нь огт мэдэхгүй байсан бол 2 (14.3%), 5 (17.4%) дугаар ангийн сурагчдын асран хамгаалагчид, 9 (18.2%), 10 (16.7%) ангийн сурагчид бусад ангийн сурагчдаас илүү мэдлэг (сайн, маш сайн)-тэй нь байсан. (Зураг 5). Яагаад

Зураг 5. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, анги, хувиар



Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын үнэлгээний дүнгээс харахад энэ талын мэдлэггүй байгаа


нь стрептококкийн бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг гурав дахин нэмэгдүүлж байна (OR 3.47, p=0.43) (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	100	48.5	41.8-55.3	173	34.8	30.7-39.1	3.47	0.41-29.2	0.43
Бага мэднэ	43	20.9	15.8-26.8	126	25.4	21.7-29.3	2.05	0.24-17.49	0.682
Дунд мэднэ	45	21.8	16.6-27.9	123	24.7	21.1-28.7	2.19	0.26-18.73	0.677
Сайн мэднэ	17	8.3	5.1-12.6	69	13.9	11.1-17.1	1.48	0.17-13.11	1.0
Маш сайн мэднэ	1	0.5	0.1-2.2	6	1.2	0.5-2.5			

Үнэлгээнд хамрагдагсад стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн тулд хоолой өвдөж байх үедээ хоолойн арчдасны шинжилгээ өгч халдвартай эсэхээ мэддэг талаар асуухад дийлэнх үнэлгээнд хамрагдагсад буюу 80.4% нь муу, огт мэдэхгүй байгаа нь энэ талаар мэдлэг хангалтгүй байгаа нь харагдаж байна (Зураг 6). Үнэлгээнд хамрагдагсадтай ярилцаж байхад 6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактери илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ авахад энэ талаар сонссоноо дурдаж байлаа.

Зураг 6. Стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн тулд хоолойн арчдасны шинжилгээ өгдөг талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэг, хувиар



Хоолой өвдөхөд стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн хоолойн арчдасны шинжилгээ өгч онош тодруулдаг талаарх мэдлэгийг үнэлэхэд тохиолдлын бүлэг хяналтын бүлгээс 7.5%-иар илүү мэдлэгтэй байсан (OR 1.37, p=0.09) (Хүснэгт 9).


Хүснэгт 9. Стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн тулд хоолойн арчдасны шинжилгээ өгдөг талаарх үнэлгээнд хамрагдагсдын мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Тийм	90	43.7	37.0-50.5	180	36.2	32.1-40.5	1.37	0.98-1.90	0.074
Үгүй	116	56.3	49.5-63.0	317	63.8	59.5-67.9			

Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэгийг үнэлэхэд нийт үнэлгээнд хамрагдагсдын 40.1% (95% CI


36.5-43.8) огт мэдэхгүй, 16.5% (95% CI 13.9-19.4) муу, 22.2% (95% CI 19.2-25.4) дунд, 17.5% (95% CI 14.8-20.4) сайн, 3.7% (95% CI 2.5-5.3) маш сайн гэж үнэлэгдсэн байна (Зураг 7).

Зураг 7. Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэг, хувиар



Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэг доорх зургаас харахад хангалтгүй байгаа нь мэдлэг дутуугаасаа хоолой өвдөх бүрд эмчид ханддаггүй байдал өвчнийг даамжруулах, хүндрэлд хүргэж магадгүйг харуулж байна. Судалгаанд хамрагдагсдын мэдлэгийг ангиар харьцуулж, үзэхэд 6 дугаар ангийн сурагчдын 57.8% огт мэдлэггүй байгаа нь бусад ангийн сурагчдаас хамгийн өндөр байсан. Харин 1 (9.7%), 2 (7.1%) дугаар ангийн асран хамгаалагчид, 9 (7.8%) дүгээр ангийн сурагчид маш сайн мэдлэгтэй байлаа (Зураг 8).

Зураг 8. Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэг, анги, хувиар




Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлгээр авч үзэхэд тохиолдол болон хяналтын бүлэг яг адилхан мэдлэгтэй байлаа (OR 0.63-0.90, $p=0.474-0.828$) (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Стрептококк бактерийн халдварыг эмчийн заавраар антибиотик хэрэглэж эмчилгээ хийлгэх талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	91	44.2	37.5-51.0	191	38.4	34.2-42.8	0.90	0.39-2.10	0.828
Бага мэднэ	29	14.1	9.8-19.3	87	17.5	14.4-21.0	0.63	0.25-1.56	0.333
Дунд мэднэ	44	21.4	16.2-27.3	112	22.5	19.0-26.4	0.74	0.31-1.79	0.493
Сайн мэднэ	33	16.0	11.5-21.5	90	18.1	14.9-21.7	0.69	0.28-1.70	0.474
Маш сайн мэднэ	9	4.4	2.2-7.8	17	3.4	2.1-5.3			

Стрептококк бактерийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн, дуустал хийхийн ач холбогдлын талаарх мэдлэгийг үнэлэхэд 42.8% (95% CI 39.2-46.5) огт мэдэхгүй, 14.2% (95% CI 11.8-17.0) муу, 20.9% (95% CI 18.0-24.0) дунд, 16.9% (95% CI 14.3-19.8) сайн, 5.1% (95% CI 3.7-6.9) маш сайн гэж үнэлэгдсэн байна (Зураг 9).

Зураг 9. Стрептококк бактерийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн, дуустал хийхийн ач холбогдлын талаар мэдлэг, хувиар



Стрептококк бактерийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн, дуустал хийхийн ач холбогдлын талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлгээр авч үзэхэд тохиолдлын бүлэг хяналтын бүлгээс бага мэдлэг мэдээлэлтэй байлаа (OR 0.92-1.22, p=0.680-1.0), (Хүснэгт 11).


Хүснэгт 11. Стрептококк бактерийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг эмчийн зааврын дагуу бүрэн, дуустал хийхийн ач холбогдлын талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	93	45.1	38.5-52.0	208	41.9	37.6-43.2	1.16	0.54-2.51	0.849
Бага мэднэ	32	15.5	11.1-20.9	68	13.7	10.9-16.9	1.22	0.53-2.84	0.680
Дунд мэднэ	40	19.4	14.5-25.2	107	21.5	18.1-25.3	0.97	0.43-2.19	1.0
Сайн мэднэ	31	15.0	10.7-20.4	88	17.7	14.5-21.2	0.92	0.40-2.11	0.832

Маш сайн мэднэ	10	4.9	2.5-8.4	26	5.2	3.5-7.5			
----------------	----	-----	---------	----	-----	---------	--	--	--


Та бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг үнэлэхэд 29.6% (95% CI 26.3-33.0) огт мэдэхгүй, 15.9% (95% CI 13.4-18.8) муу, 19.5% (95% CI 16.7-22.5) дунд, 21.5% (95% CI) сайн, 13.5% (95% CI 3.7-6.9) маш сайн гэж үнэлэгдсэн байна (Зураг 10).

Зураг 10. Та бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, хувиар



Ангиар авч үзвэл 1-5 дугаар ангийн хүүхдүүдийн асран хамгаалагчид, 6 ангийн сурагчид илүү мэдлэг муутай байсан бол 7-10 ангийн сурагчид мэдлэгийн түвшин арай илүү байлаа. Үнэлгээнээс харахад анги ахих тусам хүүхдүүдийн мэдлэг дээшилж байгаа нь харагдаж байна (Зураг 11). $P <$

Зураг 11. Бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийн нэмэгдүүлдэг талаар мэдлэг, анги, хувиар




Бусадтай ундаалах, хооллох хэрэгсэл нэг байх нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг үнэлэхэд тохиолдлын бүлэг хяналтын бүлгээс бага мэдлэг мэдээлэлтэй байна. Иймд бусадтай ундаалах, хооллох хэрэгсэл нэг байх нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, мэдээллийг өгөх нь чухал байна (OR 1.64-2.31, $p=0.004-0.189$), (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Та бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	73	35.4	29.1-42.1	135	27.2	23.4-31.2	2.31	1.28-4.17	0.004
Бага мэднэ	31	15.0	10.7-20.4	81	16.3	13.3-19.7	1.64	0.85-3.16	0.189
Дунд мэднэ	40	19.4	14.5-25.2	97	19.5	16.2-23.2	1.76	0.94-3.32	0.09
Сайн мэднэ	44	21.4	16.2-27.3	107	21.5	18.1-25.3	1.76	0.94-3.28	0.097
Маш сайн мэднэ	18	8.7	5.5-13.2	77	15.5	12.5-18.9			

Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг үнэлэхэд 28.6%(95% CI 39.2-46.5) огт мэдэхгүй, 12.5% (95% CI 18.0-24.0) муу, 18.8% (95% CI 18.0-24.0) дунд, 27.0% (95% CI 14.3-19.8) сайн, 28.6% (95% CI 3.7-6.9) маш сайн гэж үнэлэгдсэн байна (Зураг 12).

Зураг 12. Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар, мэдлэг, хувиар




Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг тохиолдол болон хяналтын бүлгээр авч үзэхэд тохиолдлын бүлэг хяналтын бүлгээс бага мэдлэг мэдээлэлтэй байна (OR 0.96-2.08, $p=0.027-0.884$) (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар тохиолдол болон хяналтын бүлэг мэдлэг, хувиар

Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	64	31.1	25.0-37.6	137	27.6	23.8-31.6	1.4	0.8-2.44	0.27
Бага мэднэ	36	17.5	12.8-23.1	52	10.5	8.0-13.4	2.08	1.10-3.92	0.027
Дунд мэднэ	37	18.0	13.2-23.6	95	19.1	15.8-22.7	1.17	0.64-2.14	0.648
Сайн мэднэ	46	22.3	17.1-28.4	144	29.0	25.1-33.1	0.96	0.54-1.71	0.884
Маш сайн мэднэ	23	11.2	7.4-16.0	69	13.9	11.1-17.1			


Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг үнэлэхэд 28.9% (95% CI 39.2-46.5) огт мэдэхгүй, 13.4% (95% CI 18.0-24.0) муу, 22.5% (95% CI 18.0-24.0) дунд, 27.3% (95% CI 14.3-19.8) сайн, 8.0% (95% CI 3.7-6.9) маш сайн гэж үнэлэгдсэн байна (Зураг 13).

Зураг 13. Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, хувиар



Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, ангиар авч үзэхэд 3 дугаар ангийн хүүхдүүдийн асран хамгаалагчдын 40% огт мэдлэггүй, 4, 5 дугаар ангийн сурагчдын асран хамгаалагчид, 6, 7 дугаар ангийн сурагчдын 30%-иас дээш нь огт мэдлэггүй, 1, 2, 4 дүгээр ангийн сурагчдын асран хамгаалагчид, 10 дугаар ангийн сурагчдын 30%-иас дээш нь сайн мэдлэгтэй байлаа (Зураг 14).

Зураг 14. Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэг, анги, хувиар



Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококк бактериар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар мэдлэгийг үнэлэхэд тохиолдлын бүлэг хяналтын бүлгээс бага мэдлэгтэй байна (OR 1.16-2.07, $p=0.053-0.854$) (Хүснэгт 15).

Хүснэгт 14. Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, таны шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар тохиолдлын болон хяналтын бүлэг мэдлэг, хувиар


Хариулт	Тохиолдлын бүлэг			Хяналтын бүлэг			OR	95% CI	P
	n	%	95% CI	n	%	95% CI			
Огт мэдэхгүй	73	35.4	29.1-42.1	130	26.2	22.4-30.2	2.07	1.03-4.18	0.053
Бага мэднэ	33	16.0	11.5-21.5	61	12.3	9.6-15.4	1.98	0.92-4.27	0.098
Дунд мэднэ	38	18.4	13.6-24.2	120	24.1	20.5-28.1	1.16	0.56-2.42	0.854
Сайн мэднэ	50	24.3	18.8-30.5	142	28.6	24.7-32.7	1.29	0.63-2.64	0.599
Маш сайн мэднэ	12	5.8	3.2-9.7	44	8.9	6.6-11.6			

3.2 Хоолойн арчдасны шинжилгээний үр дүн болон мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлсон дүн ба эрсдэлийн үнэлгээ:

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газарт 2024 оны 06 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн “6-17 насны хүүхдүүдээс стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ”-ний хариуг авахад УБ хотын найман дүүргийн 198'398 (55.50%), Сэлэнгэ аймгийн 17 сумын 16'026 (92.58%) нийт 214'424 (57.22%) хүүхдийг тус шинжилгээнд хамруулсан байна.

УБ хотоос стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ өгсөн 6-17 насны хүүхдүүдийн 5.8% (95% CI 5.7-5.9), Сэлэнгэ аймгаас стрептококк бактери илрүүлэх шинжилгээ өгсөн 6-17 насны хүүхдүүдийн 12.7% (95% CI 12.2-13.2) нь эерэг гарсан байна. Сэлэнгэ аймгийн 6-17 насны хүүхдүүдийн дунд УБ хотын 6-17 насны хүүхдүүдээс 2 дахин их стрептококк бактерийн халдвар илэрсэн байна (Зураг 15). $P <$

Зураг 15. 6-17 насны хүүхдүүдийн дундах стрептококк бактерийн халдварын тархалт, хувиар




УБ хотын стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээ өгсөн 6-17 насны хүүхдүүдийн шинжилгээний хариуг дүүргээр авч үзвэл Багануур дүүрэг 17.1% (95% CI 16.1-18.1), БГД 4.7% (95% CI 4.5-5.0), БЗД 5.4% (95% CI 5.2-5.6), Налайх дүүрэг 6.3% (95% CI 5.7-6.9), СХД 6.8% (95% CI 6.4-7.1), СБД 5.1% (95% CI 4.8-5.3), ХУД 4.7% (95% CI 4.4-5.0), ЧД 6.9% (95% CI 6.5-7.3) нь эерэг гарсан байна (Хүснэгт 15).

Хүснэгт 15. УБ хотын 6-17 насны хүүхдүүдээс стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээний хариу, дүүрэг, хувиар

Хариулт	Сөрөг			Эерэг		
	n	%	95% CI	n	%	95% CI
Багануур	4447	82.9	81.9-83.9	916	17.1	16.1-18.1
Баянгол	30828	95.3	95.0-95.5	1528	4.7	4.5-5.0
Баянзүрх	57821	94.6	94.4-94.8	3317	5.4	5.2-5.6
Налайх	6770	93.7	93.1-94.3	454	6.3	5.7-6.9
Сонгинохайрхан	21747	93.2	92.9-93.6	1576	6.8	6.4-7.1
Сүхбаатар	28118	94.9	94.7-95.2	1497	5.1	4.8-5.3
Хан-Уул	19783	95.3	95.0-95.6	982	4.7	4.4-5.0
Чингэлтэй	17329	93.1	92.7-93.5	1285	6.9	6.5-7.3
НИЙТ	186843	94.2	94.1-94.3	11555	5.8	5.7-5.9

УБ хотод стрептококк бактерийн халдвар Хан-Уул дүүрэг, Баянгол дүүрэгт хамгийн бага буюу 4.7% (95% CI 4.5-5.0) байсан. Харин Багануур дүүрэгт хамгийн их ба бусад дүүргүүдтэй харьцуулахад ойролцоогоор 3 дахин их (17.1% 95% CI 16.1-18.1) байна (Зураг 16).

Зураг 16. УБ хотын 6-17 насны хүүхдүүдийн дундах стрептококк бактерийн халдварын тархалт, дүүрэг, хувиар



Сэлэнгэ аймгийн 6-17 насны хүүхдүүдийн дунд стрептококк бактерийн халдвар Алтанбулаг 2.5% (95% CI 1.5-3.9), Баруунбүрэн 1.9% (95% CI 0.9-3.5), Баянгол 6.0% (95% CI 4.6-7.6), Ерөө 26.9% (95% CI 24.1-29.7), Жавхлант 26.0% (95% CI 21.1-31.4),


Зүүнбүрэн 2.8% (95% CI 1.6-4.6), Зүүнхараа 11.5% (95% CI 10.7-12.4), Орхон 26.2% (95% CI 19.1-34.3), Орхонтуул 18.4% (95% CI 15.1-22.1), Сайхан 17.6% (95% CI 15.2-20.2), Сант 16.4% (95% CI 10.9-23.4), Сүхбаатар 10.7% (95% CI 9.7-11.9), Түшиг 12.4% (95% CI 8.1-17.9), Хушаат 19.9% (95% CI 15.1-25.5), Хүдэр 18.2% (95% CI 15.3-21.4), Цагааннуур 13.2% (95% CI 10.5-16.3), Шаамар 18.2% (95% CI 15.1-21.6) тархалттай байсан байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Сэлэнгэ аймгийн 6-17 насны хүүхдүүдээс стрептококк бактерийн халдварыг илрүүлэх хоолойн арчдасны шинжилгээний хариу, сум, хувиар

Хариулт	Сөрөг			Эерэг		
	n	%	95% CI	n	%	95% CI
Алтанбулаг	630	97.5	96.1-98.5	16	2.5	1.5-3.9
Баруунбүрэн	420	98.1	96.5-99.1	8	1.9	0.9-3.5
Баянгол	898	94.0	92.4-95.4	57	6.0	4.6-7.6
Ерөө	711	73.1	70.3-75.9	261	26.9	24.1-29.7
Жавхлант	202	74.0	68.6-78.9	71	26.0	21.1-31.4
Зүүнбүрэн	455	97.2	95.4-98.4	13	2.8	1.6-4.6
Зүүнхараа	4954	88.5	87.6-89.3	644	11.5	10.7-12.4
Орхон	93	73.8	65.7-80.9	33	26.2	19.1-34.3
Орхонтуул	377	81.6	77.9-84.9	85	18.4	15.1-22.1
Сайхан	726	82.4	79.8-84.8	155	17.6	15.2-20.2
Сант	112	83.6	76.6-89.1	22	16.4	10.9-23.4
Сүхбаатар	2708	89.3	88.1-90.3	325	10.7	9.7-11.9
Түшиг	149	87.6	82.1-91.9	21	12.4	8.1-17.9
Хушаат	181	80.1	74.5-84.9	45	19.9	15.1-25.5
Хүдэр	494	81.8	78.6-84.7	110	18.2	15.3-21.4
Цагааннуур	453	86.8	83.7-89.5	69	13.2	10.5-16.3
Шаамар	432	81.8	78.4-84.9	96	18.2	15.1-21.6
НИЙТ	13995	87.3	86.8-87.8	2031	12.7	12.2-13.2

Сэлэнгэ аймгийн хувьд стрептококк бактерийн халдвар хамгийн өндөр Ерөө, Жавхлант, Орхон сумдад 20%-иас дээш тархалттай байсан бол стрептококк бактерийн халдвар хамгийн бага Алтанбулаг, Баруунбүрэн, Зүүнбүрэн зэрэг сумдад **2.8%**-иас доош тархалттай байсан байна (Зураг 17).

Зураг 17. Сэлэнгэ аймгийн 6-17 насны хүүхдүүдийн дундах стрептококк бактерийн халдварын тархалт, сум, хувиар



Нийт үнэлгээнд хамрагдагсдын гэр бүлийн гишүүний хоолой өвдөлт нь **стрептококк бактер** эерэг гарсан сурагчдын 91.7% (CI 95% 87.3-94.9), сөрөг гарсан сурагчдын 84.2% (CI 95% 80.8-87.2) байгаа нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг 2 дахин нэмэгдүүлж байна (OR 2.04, CI 95% 1.19-3.51, P=0.010) (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Гэр бүлийн хэн нэгэн гишүүний хоолой өвдөлтийн хувь, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Гэр бүлийн хэн нэгэн гишүүний хоолой өвддөг	Тийм	91.7	87.3-94.9	84.2	80.8-87.2	2.04	1.19-3.51	0.010
	Үгүй	8.3	5.1-12.7	15.8	12.8-19.2			

Нийт үнэлгээнд хамрагдагсдын асран хамгаалагчид бага насанд нь ам дамжуулан хооллох нь тохиолдлын бүлэгт 42.6% (CI 95% 35.9-49.5), хяналтын бүлэгт 30.3% (CI 95% 26.4-34.5) байгаа нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг **70%-аар** нэмэгдүүлж байна (OR 1.70, CI 95% 1.23-2.37, P=0.003) (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Ам дамжуулан хооллолтын хувь, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Ам дамжуулан хооллох	Тийм	42.6	35.9-49.5	30.3	26.4-34.5	1.70	1.23-2.37	0.003
	Үгүй	57.4	50.5-64.1	69.7	65.5-73.6			

Стрептококк бактерийн халдвараар өвчлөх нь гүйлсэн булчирхайн үрэвсэл буюу хоолойн мах авах мэс ажилбарт орох эрсдэлийг **68%-аар** нэмэгдүүлж байна (OR 1.68, CI 95% 0.68-4.81, P=0.315) (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Хүүхэд хоолойн махаа авахуулах мэс ажилбарын хувь, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Таны хүүхэд хоолойн махаа авахуулсан эсэх	Тийм	4.1	1.9-7.5	2.5	1.3-4.1	1.68	0.68-4.81	0.315
	Үгүй	95.9	92.5-98.1	97.5	95.9-98.7			

Стрептококк бактерийн халдвараар өвчлөх нь зүрх өвдөх эрсдэлийг **43%-аар** нэмэгдүүлж байна (OR 1.43, CI 95% 0.93-2.18, P=0.114) (Хүснэгт 20).

Хүснэгт 20. Хүүхдийн зүрх өвдөлтийн хувь, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Таны хүүхдийн зүрх өвддөг эсэх	Тийм	22.5	16.9-29.0	16.9	13.7-20.6	1.43	0.93-2.18	0.114
	Үгүй	77.5	71.0-83.1	83.1	79.4-86.3			

Үнэлгээнд нэг сая төгрөгөөс бага өрхийн орлоготой сурагчдын **16.3% (CI 95% 11.0-22.9)**, нэг сая төгрөгөөс дээш өрхийн орлоготой сурагчдын **11.8% (CI 95% 9.0-15.2)**-д стрептококк бактерийн халдвар илэрсэн. Өрхийн орлого бага байх нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг **45%-аар нэмэгдүүлж байна (OR 1.45, CI 95% 0.86-2.47, P=0.198)** (Хүснэгт 21).

Хүснэгт 21. Өрхийн дундаж орлого, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Өрхийн дундаж орлого	<1 сая	16.3	11.0-22.9	11.8	9.0-15.2	1.45	0.86-2.47	0.198
	>1 сая	83.7	77.1-89.0	88.2	84.8-91.0			

Нийт үнэлгээнд хамрагдагсдын шүд цооролт (кариес) нь тохиолдлын бүлэгт **67.9% (CI 95% 61.1-74.1)**, хяналтын бүлэгт **61.9% (CI 95% 57.4-66.2)** байгаа нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх **эрсдэлийг 30%-аар нэмэгдүүлж байна (OR 1.30, CI 95% 0.91-1.85, P=0.157)** (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Шүд цооролтын хувь, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Шүд цоорох	Тийм	67.9	61.1-74.1	61.9	57.4-66.2	1.30	0.91-1.85	0.157
	Үгүй	32.1	25.9-38.9	38.1	33.8-42.6			

Өглөөний ээлжид хичээллэдэг сурагчид нь өдрийн ээлжид хичээллэдэг сурагчдаас **24% (OR 1.30, CI 95% 0.91-1.85, P=0.157)**-иар стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг нэмэгдүүлж байна (Хүснэгт 23).

Хүснэгт 23. Хичээллэх ээлж, эрсдэл

Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Хичээллэх ээлж	Өглөө	66.0	58.1-73.3	59.7	54.9-64.3	1.24	0.88-1.74	0.233

	Өдөр	34.0	26.7-41.9	40.3	35.7-45.1			
--	-------------	------	-----------	------	-----------	--	--	--

Стрептококк бактерийн халдвараар өвчилсөн сурагчдын дунд стрептококк бактерийн халдварын эмчилгээг дутуу, огт эмчилгээ хийхгүй орших нь зүрх өвдөх эрсдэлийг **14%-иар нэмэгдүүлж байна** (OR 1.14, CI 95% 0.33-3.92, P=1.0) (Хүснэгт 24).

Хүснэгт 24. Стрептококк бактерийн халдвар, эрсдэл

.Үзүүлэлт	Шалгуур	Эмчилгээг бүрэн хийсэн		Эмчилгээг дутуу, огт хийхгүй байх		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Стрептококк бактерийн халдвараар	Өвддөг	40.6	25.0-57.8	37.5	17.4-61.7	1.14	0.33-3.92	1.000
	Өвддөггүй	59.4	42.2-75.0	62.5	38.3-82.6			


Нийт үнэлгээнд хамрагдагсдын буйл үрэвсэх нь тохиолдлын бүлэгт **41.1% (CI 95% 34.4-48.2)**, хяналтын бүлэгт **38.6% (CI 95% 34.2-43.1)** байгаа нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлийг **11%-аар нэмэгдүүлж байна** (OR 1.11, CI 95% 0.79-1.57, P=0.598) (Хүснэгт 25).

Хүснэгт 25. Буйл үрэвсэлтийн хувь, эрсдэл

.Үзүүлэлт	Шалгуур	Тохиолдол		Хяналт		OR	CI 95%	P
		%	CI 95%	%	CI 95%			
Буйл үрэвсэх	Тийм	41.1	34.4-48.2	38.6	34.2-43.1	1.11	0.79-1.57	0.598
	Үгүй	58.9	51.8-65.6	61.4	56.9-65.8			

Стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэл хамгийн өндөр нь гэр бүлийн гишүүний хоолой өвдөх байхад буйл үрэвсэх нь хамгийн бага байлаа(Зураг 18).

Зураг 18. Стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэл




Хүүхэд гадуур хооллох (OR 1.03, CI 95% 0.67-1.56, P=1.0), Гэр бүлийн гишүүн тамхи татдаг эсэх (OR 1.02, CI 95% 0.73-1.41, P=0.933) нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх 5%-иас бага эрсдэлтэй байна. Таргалалт, илүүдэл жинтэй байсан эсэх (OR 0.91, CI 95% 0.60-1.27, P=0.747), Тогтмол эмчийн үзлэгт хамрагддаг эсэх (OR 0.91, CI 95% 0.66-1.27, P=0.615), Гэр болон байшин хороололд амьдрах

(OR 0.78, CI 95% 0.56-1.08, P=0.157), Шүдээ өдөр болгон угаах нь (OR 0.75, CI 95% 0.46-1.20, P=0.256), Хоолойгоо давстай усаар зайлахгүй (OR 0.63, CI 95% 0.45-0.88, P=0.059), Таны хүүхэд дархлаа дэмжих зорилгоор амин дэм хэрэглэдэг эсэх (OR 0.85, CI 95% 0.75-1.26, P=0.419), Ариун цэврийн байгууламжийн байршил (OR 0.85, CI 95% 0.61-1.19, P=0.393) нь стрептококк бактерийн халдвараар өвчлөх эрсдэлгүй байна.


3.3 Сүүлийн 10 жилийн өвчлөлийн байдлыг тодорхойлох:

Өвчлөл: Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-өөс авсан тоон мэдээллээр Монгол улсын хэмжээнд 2015-2022 оны байдлаар зүрхний цочмог хэрэх өвчин (I00-04)-ий өвчлөлийн дунджийг авч үзэхэд хамгийн өндөр өвчлөлтэй Увс аймаг (9.31, 10'000 хүн амд) харин хамгийн бага өвчлөлтэй Баян-Өлгий аймаг (0.60, 10'000 хүн амд) байна (Зураг 19,20).

Зураг 19. Зүрхний цочмог хэрэх өвчний нийт өвчлөл, 2015-2022 оны дундаж, 10'000 хүн амд, аймгаар




Зураг 20. Зүрхний цочмог хэрэх өвчний нийт өвчлөл (I00-04)




Зүрхний цочмог хэрэх өвчний 2015-2022 оны байдлаар нийт өвчлөлийг улсын хэмжээнд авч үзэхэд 2021 онд хамгийн бага өвчлөл (0.55, 10'000 хүн амд)-тэй байсан бол 2022 онд хамгийн их өвчлөл (4.18, 10'000 хүн амд)-тэй байсан байна. Харин бусад онуудад зүрхний цочмог хэрэх өвчний өвчлөл 2.58-3.30 (10'000 хүн амд) байсан байна(Зураг 21).

Зураг 21. Зүрхний цочмог хэрэх өвчин, улсын хэмжээнд, 2015-2022 оны дунджаар




Монгол улсын хэмжээнд 2015-2022 оны байдлаар зүрхний архаг хэрэх өвчин (I05-09)-ий өвчлөлийн дунджийг авч үзэхэд хамгийн өндөр өвчлөлтэй Баянхонгор аймаг (61.29, 10'000 хүн амд) хамгийн бага өвчлөлтэй Баян-Өлгий аймаг (7.85, 10'000 хүн амд) байна (Зураг 22,23).

Зураг 22. Зүрхний архаг хэрэх өвчний нийт өвчлөл, 2015-2022 оны дундаж, 10'000 хүн амд, аймгаар




Зураг 23. Зүрхний архаг хэрх өвчний нийт өвчлөл (105-09)



Зүрхний архаг хэрэх өвчний 2015-2022 оны байдлаар нийт өвчлөлийг улсын хэмжээнд авч үзэхэд 2021 онд хамгийн бага өвчлөл (0.75, 10'000 хүн амд)-тэй байсан бол бусад онуудад зүрхний архаг хэрэх өвчний өвчлөл 1.79-2.64 (10'000 хүн амд) байсан байна(Зураг 24).

Зураг 24. Зүрхний архаг хэрх өвчин, улсын хэмжээнд, 2015-2022 оны дунджаар



Нас баралт: ЭМХТ-өөс авсан тоон мэдээллээр Монгол улсын хэмжээнд 2013-2022 оны хоорондох зүрхний архаг болон цочмог хэрх өвчний нас баралтын тоог хүснэгт 26-д үзүүлэв. Нас баралтын статистик тоон мэдээллээс харахад зүрхний архаг хэрх өвчний нас баралт сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн өндөр нас баралт 2013 онд 66, хамгийн бага нас баралт 2020, 2022 онд 20 байсан бол (Хүснэгт 26), зүрхний цочмог хэрх өвчний хамгийн өндөр нас баралт 2014 онд 10 бүртгэгдсэн байна. Харин 2020, 2022 онуудад нас баралт бүртгэгдээгүй байна (Хүснэгт 27).

Хүснэгт 26. Зүрхний архаг хэрх өвчний нас баралт улсын хэмжээнд, хүйс, оноор **10000 хүн амд бодох**

Хүйс	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Эр	37	32	31	25	31	20	18	10	16	8
Эм	29	19	29	23	20	34	14	10	11	12
Бүгд	66	51	60	48	51	54	32	20	27	20


Хүснэгт 27. Зүрхний цочмог хэрх өвчний нас баралт улсын хэмжээнд, хүйс, оноор

Хүйс	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Эр	1	6	2	1	0	1	4	0	2	0
Эм	4	4	2	2	2	3	3	0	2	0
Бүгд	5	10	4	3	2	4	7	0	4	0

2013-2022 оны хоорондох зүрхний архаг болон цочмог хэрх өвчний нас баралтыг доорх зургаас харахад нас баралт жил ирэх тусам буурах чиг хандлага ажиглагдаж байна(Зураг 25,26).

Зураг 25. Зүрхний архаг хэрх өвчний нас баралт, хүйс, оноор

Зураг 26. Зүрхний цочмог хэрх өвчний нас баралт, хүйс, оноор



ДҮГНЭЛТ:

1. Үнэлгээнд хамрагдагсдын стрептококк бактерийн халдвар, зүрхний хэрэх өвчний талаар мэдлэг мэдээлэл маш хангалтгүй байгаа нь мэдлэг дутуугаасаа хоолой өвдөх бүрд эмчид ханддаггүй байдал өвчнийг даамжруулах, хүндрэлд хүргэх эрсдэлтэйг харуулж байна.
2. Стрептококк бактерийн халдвараар өвчлөх нь зүрх өвдөх, гүйлсэн булчирхай үрэвсэж цаашлаад хоолойн махаа мэс ажилбараар авах хүртэл нөлөөлж байна.
3. Үнэлгээний асуумжийн ярилцлага хийж байхад хоолойгоо давстай усаар зайлах, хамар, шүд угаах, гарын ариун цэвэр сахих нь коронавирүст халдварт цар тахал дэлхий дахинд дэгдэж, халдвар хамгааллын дэглэм чанд баримталж хэвшсэнтэй холбоотойгоор хувийн ариун цэвэр сахих нь нэмэгдсэн байна ($OR \leq 1.0$).
4. Стрептококк бактерийн халдвараар өвчлөх нь хувийн ариун цэврээс илүү нийгмээс шалтгаалсан эрсдэлүүд их байна ($OR > 1.0$). Жишээлбэл: мэдлэг мэдээлэл бага, хичээллэх өглөөний ээлж, амьдрах нөхцөл, орлогын түвшин бага, эцэг, эх болон асран хамгаалагчийн бага насны хүүхдийг хооллох буруу хэв маяг.
5. Монгол улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн өвчлөлийн байдлаар зүрхний архаг болон цочмог хэрэх өвчний өвчлөл буурах чиг хандлага ажиглагдахгүй байгаа боловч нас баралт жил ирэх тусам буурах чиг хандлага ажиглагдаж байна.

3.4 Стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлөөс сэргийлэх зөвлөмж:

1. Зүрхний хэрэх өвчний өвчлөлийг бууруулахын тулд стрептококк бактерийн халдварыг ялган дүйх шинжилгээгээр өвчнийг эрт илрүүлж, өвчтөнд зориулсан

эмчилгээг цаг алдалгүй эхлүүлэхийн тулд эмч, эмнэлгийн ажилтнуудыг оношлуураар хангах, чадавхжуулах;

2. Зүрхний хэрэх өвчнөөр өвдөх эрсдэлийн бууруулахын тулд стрептококк бактерийн халдвар илэрсэн хүүхэд бүрд чиглэсэн эмчилгээг үйлчилгээг явуулж, орлого багатай иргэдэд эмчилгээний багцаар хангах;
3. Стрептококк бактерийн халдвар илэрсэн хүүхдүүдэд зүрхний нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч үзлэг, оношилгоо хийж дараагийн шатны эмчилгээг хийх;
4. Эрүүл мэндийн байгууллагуудаас бага насны хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчдад стрептококк бактерийн халдвар нь зүрхний хэрэх өвчний өвчлөлд хүргэдэг талаар мэдлэгийг дээшлүүлэх, халдвар авсан тохиолдолд эмчилгээг чанд дагаж мөрдөхийн ач холбогдол, эмчилгээг дутуу орхих болон огт хийлгэхгүй байхын хор уршгийг таниулах;
5. Жирэмсэн эмэгтэйчүүд болон асран хамгаалагч нарт бага насны хүүхдийг хооллохдоо амнаас ам дамжуулан хооллохгүй, хоолыг бутлах, температурыг нь шалгахдаа амаа оролцуулахгүй тусгай төхөөрөмж ашиглах, аяга халбагыг тусад хэрэглэхийн ач холбогдлын талаар мэдээлэл өгөх;
6. Өвчтөнүүд болон тэдний асран хамгаалагчид хэрэхийн халууралт, зүрхний хэрэх өвчний талаар хангалттай мэдээлэл, боловсрол, түүнчлэн хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг дагаж мөрдөхийн ач холбогдлыг таниулах, түүнчлэн амны хөндийн ариун цэвэр сахих талаар мэдлэг мэдээлэл өгөх;
7. Стрептококк бактерийн халдвар бүртгэгдсэн тохиолдолд хувийн ариун цэврийг сайтар сахих, маск зүүх, гэр болон сургууль, бусад боловсролын байгууллагууд дотоод орчны агаар сэлгэлтийг хийх, байнга хүрдэг гадаргууг цэвэрлэх, халдваргүйжүүлэх зааварчилгааг дагаж мөрдөх;

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Zühlke, L. J., Beaton, A., Engel, M. E., Hugo-Hamman, C. T., Karthikeyan, G., Katzenellenbogen, J. M., ... & Carapetis, J. (2017). Group A streptococcus, acute rheumatic fever and rheumatic heart disease: epidemiology and clinical considerations. *Current treatment options in cardiovascular medicine*, 19, 1-23.
2. Auala, T., Zavale, B. L. G., Mbakwem, A. Ç., & Mocumbi, A. O. (2022). Acute rheumatic fever and rheumatic heart disease: highlighting the role of group A

Streptococcus in the global burden of cardiovascular disease. *Pathogens*, 11(5), 496.

3. <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/rheumatic-heart-disease>
4. Coffey, P. M., Ralph, A. P., & Krause, V. L. (2018). The role of social determinants of health in the risk and prevention of group A streptococcal infection, acute rheumatic fever and rheumatic heart disease: a systematic review. *PLoS neglected tropical diseases*, 12(6), e0006577.
5. Bennett, J., Rentta, N., Leung, W., Anderson, A., Oliver, J., Wyber, R., ... & Baker, M. G. (2021). Structured review of primary interventions to reduce group A streptococcal infections, acute rheumatic fever and rheumatic heart disease. *Journal of Paediatrics and Child Health*, 57(6), 797-802.
6. Martini, A. M., Moricz, B. S., Ripperger, A. K., Tran, P. M., Sharp, M. E., Salgado-Pabón, W., & Jones, B. D. (2020). Association of novel *Streptococcus sanguinis* virulence factors with pathogenesis in a native valve infective endocarditis model. *Frontiers in microbiology*, 11, 482640.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
АНАГААХ УХААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 24/037

Улаанбаатар хот

Г Судалгаа эхлүүлэх зөвшөөрөл олгох тухай Г

Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 24/05 дугаар хурлын протоколыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилттэй "6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийн үнэлгээ" сэдэвт судалгааны төслийг судлаач, Анагаах ухааны магистр Г.Очийн удирдлаган дор 2024 онд багтаан хийж, гүйцэтгэхийг зөвшөөрсүгэй.

2.Судалгааны явцад тодорхой шалтгааны улмаас арга аргачлал өөрчлөгдөх, гадаад орон руу сорьц тээвэрлэх, Хельсинкийн тунхаглалд туссан ёс зүйн асуудал хөндөгдсөн тохиолдолд Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд мэдэгдэж, дахин хэлэлцүүлэхийг судалгааны удирдагч болон багийнханд үүрэг болгосугай.

3.Судалгааны явцын тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.

4.Судалгааны төгсгөлийн тайланг Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, судалгаа дууссан хугацаанаас хойш 2 сарын дотор багтаан Анагаах ухааны ёс зүйн хяналтын хороонд ирүүлэхийг төслийн удирдагчид үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЦЭРЭНДАВГА

149124052

ТАНИУЛСАН ЗӨВШӨӨРЛИЙН ХУУДАС

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Миний нэрийг гэдэг. Би ЭМЯ-ны харьяа НЭМҮТ-ийн НЭМҮЛЛ-д ажилладаг ба “6-15 НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН СТРЕПТОКОКК БАКТЕРИЙН ХАЛДВАРААС ҮҮДЭЛТЭЙ ЗҮРХ, СУДАСНЫ ӨВЧЛӨЛИЙН ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ” үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэж байна.

Зорилго: Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн 6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийг үнэлэх

Үнэлгээний ажлын талаар танд өгөх мэдээлэл:

Стрептококкийн бактери нь ам, хоолой, хамар, арьс, бүдүүн гэдэс, давсаг, шээс, бэлгийн замаас олддог, ихэнх зүйл нь хоргүй байдаг ч зарим зүйлийн стрептококк нь хүнд хэлбэрийн хоолойн халдвараас эхлээд эрхтэн тогтолцооны өвчин хүртэл халдварыг үүсгэдэг. Стрептококкийн төрлийн бактериудыг А болон В бүлгийн бактериуд гэж хоёр ангилдаг.

А бүлгийн стрептококк цочмог үрэвсэлт өвчнүүдийг үүсгэдэг бөгөөд эмчлэхгүй, дутуу эмчилсэн тохиолдолд зүрхний хэрэх өвчинд хүргэдэг. Зүрхний хэрэх өвчин өмнө нь халдварласан стрептококкийн халдвараас үүдэлтэй, аутоиммуны хариу урвалын улмаас зүрхний хавхлагийг гэмтээдэг бөгөөд жил бүр энэ өвчнөөр дэлхийн хэмжээнд 288,348 хүн нас бардаг. Эпидемиологийн судалгаагаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал нийгэм, эдийн засаг хөгжиж буй орны хүн амын дунд стрептококкийн халдвар их байгааг олон улсын судлаачид тогтоосон байна. Тиймээс бид сургуулийн насны хүүхдийн стрептококкийн бактерийн халдвар, зүрхний хэрэх өвчин, зүрх судасны өвчлөлийн эрсдлийн цогц харилцан үйлчлэлийг үнэлэх шаардлагатай байна.

Мэдээлэл цуглуулах арга:

Энэхүү үнэлгээнд Улаанбаатар хот, Сэлэнгэ аймгийн нийт 8 Ерөнхий боловсролын сургуулийн 1-10 дугаар ангийн 6-15 насны хүүхдүүдийг хамруулах болно.

Бид танаас таны асрамжид байдаг 6-15 насны хүүхдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийг үнэлэх талаар асуумж авах бөгөөд үүнд та 20-30 минут зарцуулна.

Та үнэлгээнд хэрхэн оролцох вэ:

Танд энэхүү үнэлгээний мэдээлэл цуглуулах асуумжид хариулах эсэхээ шийдэх хугацаа олгоно. Та энэ хугацаанд тодруулахыг хүссэн зүйлсээ надаас эсвэл манай багийн ахлагчаас асуух боломжтой бөгөөд та үнэлгээний асуумжид хариулахаа шийдвэл, зөвшөөрлийн хуудсан дээр гарын үсэг зурж, баталгаажуулсны дараа үнэлгээний асуумжид хариулж болно.

Нууцлал:

Таны өгсөн мэдээллийн нууцыг бид бүрэн хариуцна. Бид таны өгсөн мэдээллийг зөвхөн үнэлгээний мэдээлэл цуглуулах зорилгоор ашиглана. Үнэлгээний баримт бичигт танай өрх, хаяг болон хүүхдийн нэрийн талаар огт байхгүй байх бөгөөд зөвхөн тусгай тоогоор илэрхийлсэн код таны хүүхдийн талаарх мэдээллийг төлөөлөх болно.

Та ямар эрхтэй вэ:

Та манай үнэлгээний асуумжид огт хариулахгүй байж болно, эсвэл хүссэн үедээ үнэлгээний асуумжид хариулахгүй татгалзах эрхтэй. Таныг үнэлгээнд оролцохоос татгалзсаны төлөө эмнэлгийн тусламж, үйлчилгээ авахад ямар нэгэн саад бэрхшээл, дарамт, шахалт үзүүлэхгүй болно.

Хэрэв энэ үнэлгээтэй холбоотой биднээс тодруулах асуудал байвал холбогдох албан тушаалтантай холбоо барьж лавлаж болно.

Холбогдох утас:

НЭМҮТ-ийн захирал, бичиг хэрэг – 11458645

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний лавлагаа лабораторийн дарга Г.Оч – 88021964

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний лавлагаа лабораторийн чанарын менежер П.Гантуяа – 99299786

ЗӨВШӨӨРӨЛ

Би дээрх мэдээлэлтэй танилцаж үнэлгээний зорилго, ач холбогдлыг ойлгосон тул үнэлгээний мэдээлэл цуглуулах асуумжид хариулахыг зөвшөөрч байна.

Суралцагч (асрамжлагч): овогнэр /гарын үсэг/

Судлаач: овогнэр /гарын үсэг/

2024 оны дугаар сарын өдөр

Танд баярлалаа



6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийн үнэлгээний асуулга

ХАЯГИЙН ХЭСЭГ	
Сургуулийн нэр, дугаар: _____	Суралцагчийн анги, бүлэг: ____ ... ____
Хүүхдийн нэр, дугаар: Нэр: _____	Хүүхдийн хүйс 1. Эр 2. Эм
Хүүхдийн төрсөн огноо (он/сар/өдөр): _____ / _____ / _____	Судлаачийн нэр: Нэр: _____
Асуулга авсан огноо (он/сар/өдөр): 2024/____/____	Сургуулийн байршил: 1. Дүүрэг 2. Аймгийн төв 3. Сумын төв
Хичээлийн аль ээлжинд суралцдаг вэ?	Өглөөний ээлж 1 Өдрийн ээлж 2

Ярилцлага өгөгч нь 6-15 нас хүрсэн ЕБС-ийн суралцагчийн асран хамгаалагч байна. Хэрэв хүүхдийн асран хамгаалагч нь ярилцлага өгөх чадваргүй бол тухайн хүүхдэд хамаарал (ах, эгч, бусад хамаатан) бүхий 15-17 насны хүүхдээс ярилцлага авч болно.	Ярилцлага эхэлсэн: Цаг : Минут ____ : _____
Сайн байна уу Намайг (судлаачийн нэр) гэдэг. Бид “6-15 насны хүүхдүүдийн стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн эрсдэлийн үнэлгээ”-ний ажлыг гүйцэтгэж байна. Би тантай стрептококк бактерийн халдвараас үүдэлтэй зүрх, судасны өвчлөлийн талаар ярилцах юм. Бидний ярилцлага ойролцоогоор 20-30 минут үргэлжилнэ. Одоо ярилцлагаа эхэлж болох уу	
Зөвшөөрлийн хуудастай танилцсан уу 1. Тийм 2. Үгүй (Үгүй бол, та танилцана уу)	Зөвшөөрлийн хуудастай (амаар эсвэл бичгээр) танилцаад зөвшөөрсөн эсэх 1. Тийм 2. Үгүй (Үгүй бол судалгаанаас хасах)

Ярилцлага хийсэн хэл	Монгол хэл 1 Казах хэл 2 Бусад 3
Ярилцлага өгөгчийн төрөлх хэл	Монгол хэл 1 Казах хэл 2 Буриад хэл 3 Бусад (тодруул) 4

Ярилцлагын явцад орчуулагч ашигласан уу	Тийм, ярилцлагын турш 1 Тийм, ярилцлагын зарим хэсэгт 2 Үгүй, орчуулагч ашиглаагүй 3
Ярилцлагын үр дүн: Ярилцлага бүрэн аваагүй тохиолдолд багийн ахлагчтай зөвлөлдөнө	Бүрэн 1 Дутуу 2 Татгалзсан 3 Бусад (<i>модруул</i>) 4

А. ЕРӨНХИЙ АСУУМЖ

№	Асуулт	Хариулт	
A1	Орон сууцны төрөл	1. Гэр 2. Хашаа байшин 3. Нийтийн орон сууц 4. Нийтийн байр	2→A5 3→A5 4→A5
A2	Танай гэр ямар шалтай вэ?	1. Шалгүй 2. Модон шалтай 3. Бетонон буюу цутгамал шалтай	
A3	Танай гэр хүйтний улиралд дээврээ давхарладаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
A4	Танай гэр хүйтний улиралд туургаа давхарладаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	1→A7 2→A7 3→A7
A5	Танай орон сууцны шалны материал юу вэ?	1. Шалгүй 2. Модон шалтай 3. Паркет/ламинат 4. Плита 5. Бетонон буюу цутгамал шалтай 6. Бусад	
A6	Танай орон сууц дулаалгатай юу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
A7	Танайх үүдний амбаартай юу? (Нийтийн орон сууцанд амьдардаг бол алгасах)	1. Тийм 2. Үгүй	

A8	Танайх тог цахилгаантай юу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм, төвлөрсөн систем 2. Тийм, Сэргээгдэх эрчим хүч 3. Хосолсон 4. Үгүй 5. Мэдэхгүй 	
A9	Танайх ундны усаа ямар эх үүсвэрээс авдаг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Хашаандаа худагтай 2. Нийтийн худгаас 3. Байгалийн уснаас 4. Төвлөрсөн усан хангамжаас 5. Савласан ус 6. Хурын ус 	
A10	Танайх ахуйн хэрэглээний усаа ямар эх үүсвэрээс авдаг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Хашаандаа худагтай 2. Нийтийн худгаас 3. Байгалийн уснаас 4. Төвлөрсөн усан хангамжаас 5. Савласан ус 6. Хурын ус 	
A11	Танайд сүүлийн 1 сарын хугацаанд хангалттай хэмжээгээр ус байхгүй байсан тохиолдол байгаа юу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй 	
A12	Танай гэр ямар бие засах газар ашигладаг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Нүхэн жорлон 2. Ил задгай 3. Боловсон 00 	
A13	Танай сургууль ямар бие засах газар ашигладаг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Нүхэн жорлон 2. Ил задгай 3. Боловсон 00 4. Хосолсон 	
A14	Танай гэр гар угаах газар байгаа юу?	<ol style="list-style-type: none"> 1. Тогтсон гар угаах газартай /тосгуур, цорго/ 2. Тогтсон гар угаах газаргүй /Хувин, данх, сэнжтэй аяга, шил/ 3. Мэдэхгүй 	
A15	Танай сургууль гар угаах газар байгаа юу?	<ol style="list-style-type: none"> 1. Тогтсон гар угаах газартай /тосгуур, цорго/ 2. Тогтсон гар угаах газаргүй /Хувин, данх, сэнжтэй аяга, шил/ 3. Мэдэхгүй 	

A16	Орон сууцны халаалт	<ol style="list-style-type: none"> 1. Галладаг 2. Төвийн халаалттай 3. Шалны халаалттай 4. Тениэр халаадаг 5. Нам даралтын зуухаар халаадаг 	
A17	Танай өрхийн дундаж орлого	<ol style="list-style-type: none"> 1. 1 саяас доош 2. 1-2 сая 3. 2-3 сая 4. 3 саяас дээш 5. Мэдэхгүй 	
A18	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг голчлон ямар эмнэлгээр авдаг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. 1-р шатлалын эмнэлэг 2. 2-р шатлалын эмнэлэг 3. 3-р шатлалын эмнэлэг 4. Хувийн эмнэлэг 	
A19	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хэдий хэр хугацаа зарцуулдаг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. 1-5 хоног 2. 7-10 хоног 3. 10 дээш 	
A20	Өвдөх тоолондоо авч чаддаг уу?	<ol style="list-style-type: none"> 1. Байнга 2. Заримдаа 3. Огт очдоггүй 	
A21	Эм, тариагаа эрүүл мэндийн даатгалаар авч чаддаг уу?	<ol style="list-style-type: none"> 1. Байнга 2. Заримдаа 3. Огт авдаггүй 	
A22	Та давтан болон урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг уу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй 	
A23	Таньд эмч, эмнэлгийн ажилтнууд зөвлөгөө мэдээлэл хэр өгдөг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Огт өгдөггүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн 	

В. ХҮҮХДИЙН ТАЛААХ ЕРӨНХИЙ АСУУМЖ

№	Асуулт	Хариулт	
B1	Таны хүүхдэд хоолой өвдөх, халуурах, лимфийн зангилаа хавагнах зэрэг шинж тэмдгүүд илэрч байсан уу?	<ol style="list-style-type: none"> 1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй 	2→B3 3→B3
B2	Тийм бол ямар давтамжтай өвддөг вэ?	<ol style="list-style-type: none"> 1. Жилд 1 удаа 2. Хүйтний улиралд дунджаар 2-3 удаа 	

		3. Мэдэхгүй 4. Бусад	
B3	Таны хүүхэд хоолойны арчдасын шинжилгээ өгч байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→B8 3→B8
B4	Таны хүүхэд стрептококк бактерийн халдвартай гэж илэрсэн үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
B5	Бусад үүсгэгчийн нэрийг бичнэ үү		
B6	Тийм бол хүүхдээ стрептококкийн бактерийн халдвартай гэдгийг анх яаж мэдсэн бэ?		
B7	Хэрэв тийм бол стрептококкийн халдварын төрлийг бичнэ үү. (Жишээ нь: стрептококк г.м судлаач тайлбарлана)		
B8	Та хүүхдийнхээ хоолой өвдөх тоолонд эмчид ханддаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	1→B10
B9	Үгүй бол эмчилгээг хэний заавраар сонгож хэрэглэдэг вэ?		
B10	Таны хүүхэд стрептококкийн халдвар болон түүний хүндрэлийн эсрэг ямар нэгэн эм ууж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→B12 3→B12
B11	Та хүүхдийнхээ эмчилгээг бүрэн дуусгаж байсан уу?	1. Эмчийн зааврын дагуу эмчилгээг бүрэн хийдэг 2. Хаяадаа эмчилгээг дутуу хийдэг 3. Эмчилгээг огт хийдэггүй	
B12	Таны хүүхэд хоолойн махаа авхуулж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
B13	Таны хүүхдийн зүрх өвддөг үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→B19 3→B19
B14	Зүрхний хэрэх өвчний шинж тэмдэг (Жишээлбэл: Цээжээр өвдөх, амьсгал давчдах, ядрах) илэрсэн үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
B15	Таны хүүхэд зүрх судасны эмчид үзүүлж байсан уу?	1. Тийм	

		2. Үгүй 3. Мэдэхгүй	2→B19 3→B19
B16	Таны хүүхэд зүрхний цахилгаан бичлэг хийлгэж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
B17	Таны хүүхэд зүрхний хэрэх өвчтэй гэж оношлогдож байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
B18	Тийм бол оношоо бичнэ үү		
B19	Таны хүүхэд гадуур хооллодог уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→B21 3→B21
B20	7 хоногт хэдэн удаа гадуур хооллодог вэ?		
B21	Таны хүүхэд стрептококкийн халдвартай холбоотой үе мөч өвдөх хүндрэл үүсэж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
B22	Таны хүүхэд дархлаа дэмжих зорилгоор ямар нэгэн амин дэм хэргэлдэг үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→B24 3→B24
B23	Хэрэглэдэг бол ямар амин дэм хэрэглэдэг вэ?	1. Мульти витамин 2. Д витамин 3. С витамин 4. Бусад	
B24	Таны хүүхэд гадуур хооллодог уу?	1. Байнга 2. Заримдаа 3. Огт иддэггүй	

С. ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛ

№	Асуулт	Хариулт	
C1	Танай гэр бүлийн хэн нэгэн гишүүний хоолой өвдөж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→C4 3→C4
C2	Тийм бол хэр давтамжтай өвддөг вэ?		

C3	Танай гэр бүлийн хэн нэгэн гишүүн стрептококк бактерийн халдвартай гэж оношлогдож байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C4	Танай гэр бүлийн хэн нэгэн гишүүн зүрх судасны өвчнөөр өвчилж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→C6 3→C6
C5	Танай гэр бүлийн хэн нэгэн гишүүн зүрхний хэрэх өвчтэй гэж оношлогдож байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C6	Танай гэр бүлд тамхи татдаг хүн байдаг уу?	1. Тийм 2. Үгүй	
C7	Таны хүүхэд таргалалт, илүүдэл жинтэй юу? Өмнө нь өртөж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C8	Таны хүүхэд тогтмол дунд зэргийн эрчимтэй дасгал хөдөлгөөн хийдэг үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C9	Тогтмол өндөр эрчимтэй дасгал хөдөлгөөнийг ямар давтамжтай хийдэг вэ?		
C10	Таны хүүхэд тогтмол өндөр эрчимтэй дасгал хөдөлгөөн хийдэг үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C11	Тогтмол дунд зэргийн эрчимтэй дасгал хөдөлгөөнийг ямар давтамжтай хийдэг вэ?		
C12	Танай гэр бүлийн гишүүд тусдаа аяга, таваг, халбага, сэрээ хэрэглэдэг үү?	1. Тийм 2. Үгүй	
C13	Та хүүхдээ бага байхад амнаасаа хооллодог байсан уу?	1. Тийм 2. Үгүй	
C14	Таны хүүхэд хоолойгоо давстай усаар зайлах, угаах, хамар угааж хэвшсэн үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C15	Таны хүүхэд шүдээ өдөр болгон угаадаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→C18 3→C18
C16	Таны хүүхэд шүдээ өдөрт хэдэн удаа угаадаг вэ?		
C17	Таны хүүхэд шүдээ угаадаг ч, шүдийг нь зөв угаалгаж сургасан уу?	1. Тийм 2. Үгүй	

		3. Мэдэхгүй	
C18	Таны хүүхдэд цоорсон шүд байгаа юу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	2→C20 3→C20
C19	Та хүүхдийнхээ цоорсон шүдийг эмчлүүлсэн үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C20	Таны хүүхдийн буйл үрэвсэж байсан уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C21	Та тогтмол эмчийн үзлэгт хамрагддаг уу?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
C22	Та 1-ээс 10 хүртэлх оноогоор эрүүл мэндээ хэрхэн үнэлэх вэ?		

D. МЭДЛЭГ БА ХАНДЛАГА

№	Асуулт	Хариулт	
D1	Стрептококкийн халдвар таны эрүүл мэндэд удаан хугацаанд нөлөө үзүүлж болзошгүйг та мэдэх үү?	1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн	
D2	Стрептококкийн бактерийн халдвар ба зүрхний хэрэх өвчний хоорондын хамаарлыг та хэр мэдэх вэ?	1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн	
D3	Та өөрийгөө зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийн талаар хэр мэдлэгтэй гэж боддог вэ?	1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн	
D4	Та стрептококк бактерийн халдварыг илрүүлэхийн тулд хоолойн арчдасны шинжилгээ өгдгийг мэдэх үү?	1. Тийм 2. Үгүй 3. Мэдэхгүй	
D5	Стрептококкийн халдварыг эмчлэхийн тулд антибиотик хэрэглэх талаар та мэддэг үү?	1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн	

D6	Стрептококкийн халдварын эсрэг антибиотик эмчилгээг дуустал эмчлэх талаарх ач холбогдлыг та мэдэж байна уу?	<ol style="list-style-type: none"> 1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн 	
D7	Та халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд өдөрт гараа хэр олон удаа угааж, эрүүл ахуйг сахидаг вэ?		
D8	Та бусадтай нэг сав суулганаас ундаалах, хооллох зэрэг нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг гэдгийг мэдэх үү?	<ol style="list-style-type: none"> 1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн 	
D9	Та хүүхдээ бага балчир насанд амнаасаа дамжуулан хоолловол стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг гэдгийг мэдэх үү?	<ol style="list-style-type: none"> 1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн 	
D10	Та амны хөндийн ариун цэврийг муу сахих, шүд цоорох нь стрептококкийн нянгаар халдварлах эрсдэлийг нэмэгдүүлдэг гэдгийг мэдэх үү?	<ol style="list-style-type: none"> 1. Огт мэдэхгүй 2. Бага 3. Дунд 4. Сайн 5. Маш сайн 	
D11	Стрептококкийн халдвар, зүрхний хэрэх өвчин, зүрх судасны эрсдэлт хүчин зүйлстэй холбоотой хуваалцахыг хүсэж буй нэмэлт мэдээлэл, санал хүсэлт байна уу?		

Энэхүү үнэлгээнд оролцсон танд баярлалаа. Таны санал хүсэлт бидний үнэлгээнд үнэ цэнэтэй байх болно.